

Санхүүгийн зохицуулах хорооны
2006 оны 9 дүгээр сарын 15-ны
өдрийн 37 дугаар тогтоолын
хавсралт

НИЙТЭД САНАЛ БОЛГОН ГАРГАХ ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭХ ТУХАЙ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. “Үнэт цаасны зах зээлийн тухай” болон “Компанийн тухай” хуульд заасан журмын дагуу үнэт цаас гаргагчаас нийтэд санал болгон гаргаж байгаа үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хороонд /цаашид “Хороо”гэх/ бүртгэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасах, үнэт цаасны танилцуулгыг нийтэд сурталчлахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан 50-иас дээш тооны этгээдэд үнэт цаасаа санал болгон гаргаж бүртгүүлэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасуулах хүсэлтээ энэхүү журамд заасан холбогдох баримт бичгийн хамт Хороонд ирүүлнэ.

1.3. Урьд нь нийтэд санал болгон гаргасан үнэт цаасыг нэмж гаргахдаа хаалттай худалдахаар шийдвэрлэсэн бол мөн энэхүү журмын дагуу Хороонд бүртгүүлнэ.

ХОЁР. Нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгүүлэхэд бүрдүүлэх баримт бичиг

2.1. Нийтэд санал болгон үнэт цаас гаргахыг хүссэн этгээд үнэт цаасаа бүртгүүлэхийг хүссэн өргөдөл, үнэт цаас гаргагчийн болон гаргах үнэт цаасны талаархи танилцуулга, хууль болон энэ журамд заасан холбогдох баримт бичгийг тус бүр 2 хувь үйлдэж Хороонд ирүүлнэ. Өргөдөл, танилцуулгын нэг хувь нь эх бичиг байна.

2.2. Өргөдлийг энэхүү журмын 1 дүгээр хавсралт ёсоор баталсан маягтын дагуу үйлдэнэ.

2.3. Өргөдөл, танилцуулга болон тэдгээрт хавсаргасан холбогдох баримт бичгийг Монгол хэлээр үйлдэнэ. Хэрэв холбогдох баримт бичгийн эх хувь нь гадаад хэл дээр үйлдэгдсэн бол тэдгээрийг албан ёсны Монгол орчуулгын хамт ирүүлнэ.

2.4. Өргөдөл, танилцуулга, бусад баримт бичгийг эмхэтгэн нүүр бүрийг эхнээс нь дугаарлаж, нийт хэдэн нүүр баримт бичиг ирүүлснийг тэмдэглэж, нүүр тус бүрийн доод талд үнэт цаас гаргагчийн тэмдгийг дарсан байна.

2.5. Нийтэд санал болгон гаргах үнэт цаасны тухай танилцуулга нь үндсэн хоёр хэсгээс бүрдэх ба түүнд “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 7.3, 7.4-д зааснаас гадна энэ журмын 2.6, 2.7-д заасан мэдээллийг тусган, холбогдох баримт бичгийг хавсаргана.

2.6. Танилцуулгын эхний хэсэгт үнэт цаас гаргагчийн талаар дараахь мэдээллийг тусгана.

2.6.1. үнэт цаас гаргагчийн түүх, үйл ажиллагааны төрөл, хэтийн төлөв, үйлдвэрлэл үйлчилгээний үндсэн чиглэл, тухайн зах зээлд үнэт цаас гаргагчийн эзлэх байр суурийн талаархи мэдээлэл, судалгаа;

2.6.2. үнэт цаас гаргагчийн зохион байгуулалт, удирдлагын бүтэц, салбар, төлөөлөгчийн газар, нэгжийн тухай танилцуулга;

2.6.3. үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлд бүртгэгдсэн дүрмийн хуулбар;

2.6.4. үнэт цаасыг нийтэд санал болгон гаргах тухай үнэт цаас гаргагчийн эрх бүхий байгууллагын шийдвэр. Хэрэв уг үнэт цаасыг гаргах нь тухайн компанийн хувьд их хэмжээний хэлцэлд тооцогдохоор бол шийдвэрийг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу гаргасан тухай мэдээлэл;

2.6.5. Сангийн сайдын 2004 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 248 тоот тушаалаар баталсан “Санхүүгийн тайлан, түүний тодруулга бэлтгэх заавар”, Хорооноос баталсан “Үнэт цаас гаргагч, зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын санхүүгийн тайланд нэмэлт тодруулга бэлтгэх журам”-д заасан нэмэлт тайлбар, тодруулгыг бүрэн тусгасан сүүлийн 3 жилийн болон үнэт цаасыг бүртгүүлэх зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргахын өмнөх улирлын аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан;

Шинээр нээлттэй компани байгуулж, хувьцаагаа нийтэд санал болгон бүртгүүлэхээр хүсэлт гаргаж байгаа бөгөөд үүсгэн байгуулагч нь аж ахуйн нэгж бол сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан, тайлбар, тодруулгын хамт, иргэн бол банкинд хугацаа хэтэрсэн зээлийн өргүй болох талаар өр барагдуулах албаны тодорхойлолт;

2.6.6. Үнэт цаас гаргагч компани болон түүний толгой, охин компани болон хяналтын багцыг эзэмшигчид, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд нь нь хугацаа хэтэрсэн зээлийн өргүй болох талаар банкны өр барагдуулах алба, харилцагч банкны тодорхойлолт;

2.6.7. Компанийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан журмын дагуу өрийг хувьцаагаар сольж байгаа бол энэ тухай хувь нийлүүлэгчдийн хурлаас гаргасан шийдвэр, өрийг хувьцаагаар солих төсөл, зээлдүүлэгч харилцагчийн зөвшөөрөл, өр үүссэнтэй холбогдох болон нягтлан бодох бүртгэлд тусгасныг нотлох үндсэн баримт;

2.6.8. үнэт цаасыг хаалттай захиалгаар гаргах үед төлбөрийг эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр хийхийг зөвшөөрсөн бол тэдгээрийн үнэлгээний талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр;

2.6.9. “Ашигт малтмалын тухай хууль”-ийн 5.6-д заасан шаардлагын дагуу хувьцаагаа нийтэд санал болгон худалдахаар бүртгүүлж байгаа бол орд газрын нөөцийн үнэлгээний талаар эрх бүхий байгууллагын дүгнэлт;

2.6.10. үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэн баталгаажуулсан материал;

2.6.11. хууль тогтоомжид заасны дагуу бүртгүүлэх зөвшөөрлийн хураамж төлсөн баримт;

2.7. Танилцуулгын хоёрдахь хэсэгт гаргаж буй үнэт цаасны талаар дараахь мэдээллийг тусгана:

2.7.1. үнэт цаасны төрөл, хэлбэр;

2.7.2. үнэт цаас эзэмшигчийн эрх;

2.7.3. өрийн бичиг /бонд/ гаргаж байгаа бол хугацаа, хүүгийн хэмжээ, хүү нь тогтмол, хөвөх зэргийн алин болох, хүү төлөх хугацаа, хугацаанаас нь өмнө эргүүлэн худалдаж авах нөхцөлтэй эсэх;

2.7.4. өрийн бичиг гаргагчаас хүлээх үүрэг, компанийн өөрийн хөрөнгө, үл хөдлөх хөрөнгө бусад этгээдээс гаргах барьцаа, батлан даалт, тэдгээрийн зөвшөөрөл;

2.7.5. үнэт цаасыг анхдагч зах зээлд арилжаалах арга хэлбэр, график;

2.7.6. үнэт цаасыг биетээр гаргах бол түүний загварын хуулбар;

2.7.7. урьд нь үнэт цаас гаргаж байсан эсэх тухай мэдээлэл, үнэт цаасны төрөл, гаргасан огноо, нийт хэмжээ, төлөгдөх буюу төлөгдсөн хэмжээ, өрийн бичиг гаргасан бол үндсэн болон хүүгийн төлбөрийг хугацаанд нь барагдуулж байсан тухай үнэт цаасны төлбөр тооцооны байгууллагын тодорхойлолт;

2.7.8. шинээр болон нэмж гаргаж байгаа энгийн хувьцааны нэрлэсэн үнэ буюу худалдахаар санал болгох үнийг тогтоосон үндэслэл тооцоо, энэ үнийг тогтоосон Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр;

2.7.9. Компанийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу нэмж гаргаж байгаа хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх журам, энэ талаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлсэн тухай баримт бичиг, *тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхийг хэрэгжүүлэх эсэх тухай асуудлыг хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцсэн тухай тэмдэглэл, гарсан шийвэрийн хувь;*

/Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 120 тоот тогтоолоор өөрчлөн найруулсан/

2.7.10. хаалттай захиалгаар хувьцаа нэмж гаргаж байгаа, эсхүл давуу эрхийн хувьцааг хаалттай захиалгаар гаргаж байгаа бол худалдан авах санал гаргаж буй захиалагчдын нэр, тэдэнд санал болгож буй үнэ, энэ үнийг тогтоосон үндэслэл, *энэ үнэ нь үнэт цаасыг арилжаалж эхлэхээс өмнөх сүүлийн 6 сарын зах зээлийн дундаж ханшинаас, сүүлийн 6 сард арилжаалагдаагүй бол нийт арилжааны дундаж ханшаас багагүй байна,* хаалттай захиалгаар гаргаж буй шалтгаан, үндэслэл, энэ нь сонирхлын зөрчилтэй хэлцэл бол уг хэлцлийг Компанийн тухай хуулийн 86 дугаар зүйлд заасан журмын дагуу байгуулсан болохыг нотлох баримт;

/Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 120 тоот тогтоолоор өөрчлөн найруулсан/

2.7.11. үнэт цаас гаргах замаар хуримтлуулах хөрөнгийг зарцуулах төсөл, эдийн засгийн үр ашгийн тооцоо;

2.7.12. хувьцаа шинээр болон нэмж гаргаж байгаа бол компанийн бизнес төлөвлөгөө;

2.7.13. үнэт цаасыг арилжаалахад санал болгох /олон нийт, үнэт цаас эзэмшигчид, нэр бүхий этгээд гэх зэрэг/ хүрээ;

2.7.14. тухайн үнэт цаасыг худалдан авснаар хөрөнгө оруулагчид учирч болох эрсдэл, эрсдлийн шинжилгээ;

2.7.15. хувьцааны захиалга авах замаар шинээр хувьцаат компани байгуулж байгаа бол үүнтэй холбогдох үйл ажиллагааг Компанийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Хорооноос баталсан “Хувьцааны захиалга авах журам”-ын дагуу зохион байгуулах бөгөөд захиалгын хуудасны нэг хувийг Хороонд ирүүлнэ.

2.7.16. ХХК-ийг ХК болон өөрчлөн байгуулж, нийтэд санал болгон хувьцаа гаргаж байгаа бол ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн хувьцааг ХК-ийн хувьцаа болгон хөрвүүлэх тооцоо;

2.7.17. үнэт цаасыг андеррайтераар дамжуулан анхдагч зах зээлд худалдахаар төлөвлөж байгаа бол байгуулах гэрээний төсөл, өөрөө анхдагч зах зээлд худалдах бол мэдээллийг нийтэд сурталчлах журам, төлөвлөгөө;

2.8. Аймаг, нийслэлийн Засаг даргаас нийтэд санал болгон гаргах өрийн бичгийн тухай танилцуулгад энэ журмын 2.6.5 - 2.6.8 болон 2.6.10, 2.6.11, 2.7.8-2.7.10, 2.7.12, 2.7.15, 2.7.16-д заасан мэдээлэл хамаарахгүй.

ГУРАВ. Үнэт цаасыг бүртгэх, арилжаалах зөвшөөрөл олгох

3.1. Хороо Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 7 дугаар зүйл, энэ журмын 2 дугаар зүйлд заасны дагуу үнэт цаас гаргагчаас ирүүлсэн өргөдөл, танилцуулга, бусад баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 30 хоногийн дотор хянаж, шаардлага хангасан гэж үзвэл тухайн үнэт цаасыг бүртгэх тухай шийдвэр гаргана.

3.2. Асуудал хариуцсан мэргэжилтэн нь хүлээн авсан өргөдөл, танилцуулга, хавсаргасан баримт бичгийг холбогдох хууль болон энэхүү журмын дагуу хянан нягталж, Хороо шийдвэр гаргахад шаардлагатай бэлтгэл ажиллагааг гүйцэтгэнэ.

3.3. Энэ журмын 3.2-т заасан өргөдөл танилцуулга болон холбогдох бичиг баримт нь алдаатай эсхүл бүрдэл дутуу, шаардлага хангахгүй нөхцөлд алдааг засуулах, дутуу баримт бичгийг нөхөн бүрдүүлэх, шаардлагатай зарим баримт бичгийг эрх бүхий байгууллагаар баталгаажуулж ирүүлэхийг шаардаж болох ба энэ тохиолдолд энэ журмын 3.1-д заасан өргөдөл хянах хугацааг өргөдлийн бүрдэл бүрдсэн өдрөөс эхлэн тооцно.

3.4. Хороо Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 7.10-д заасан үндэслэл болон хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр үнэт цаасыг бүртгэхээс татгалзаж болно. Энэ тохиолдолд өргөдөл гаргагчид татгалзах болсон үндэслэл, шалтгааныг албан ёсоор мэдэгдэнэ.

3.5. Хороонд ирүүлсэн өргөдөл, танилцуулга, нэмэлт баримт бичгийн эх хувийн хуудас бүр дээр “СЗХ бүртгэв” тэмдэг дарж, албан ёсны хариу бичгийн хамт үнэт цаас гаргагчид буцаана.

3.6. Нийтэд санал болгон гаргаж, Хороонд бүртгүүлсэн бүх төрлийн үнэт цаасыг Хорооны шийдвэр гарснаас хойш ажлын 3 хоногт багтаан Ажлын алба Монгол улсын үнэт цаасны зах зээл дээр худалдахаар зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэж авна.

3.7. Хороо нь үнэт цаасыг бүртгэх тухай шийдвэр, бүртгэлийн хуулбарыг үнэт цаас гаргагчид хүргүүлнэ.

3.8. Энэ журмын 3.6-д заасан бүртгэл нь уг үнэт цаасыг төлбөр, тооцоо, хадгаламжийн болон арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлэх үндэслэл болно.

3.9. Үнэт цаасыг арилжаалах болон төлбөр тооцоо, хадгаламж эрхлэх байгууллагад бүртгүүлсний дараа энэ журмын долдугаар хэсэгт заасан нийтэд сурталчлахтай холбоотой арга хэмжээг авч хэрэгжүүлэн Хороонд мэдэгдэнэ.

3.10. Хорооны Ажлын алба энэ журмын долдугаар хэсэгт заасан нийтэд сурталчлах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, сонирхогч этгээдийг шаардлагатай мэдээллээр хангасан, нийтэд үнэн зөв, бодит мэдээлэл хүргэсэн гэж үзвэл арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасны арилжааг эхлүүлэхийг зөвшөөрсөн тухай бичгээр мэдэгдэл хүргүүлнэ.

3.11. Үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох үнэ нь уг үнэт цаасны Хороонд бүртгэсэн нэрлэсэн үнэ байна.

3.12. Үнэт цаас гаргагч нь гаргасан үнэт цаасыг арилжаалж эхэлснээс хойш улирал бүр болон арилжаалж дууссаны дараа Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9.6-д заасан тайланг энэ журмын хавсралт 3-ын дагуу гаргаж Хороонд ирүүлнэ.

3.13. Үнэт цаас гаргагч нь бүртгүүлснээс хойш нэг жилийн дотор үнэт цаасаа арилжаалж дуусаагүй бол жил бүр нийтэд сурталчлах мэдээллээ шинэчлэхээр Хороонд энэ журмын 2-т заасан баримтыг бүрдүүлж ирүүлнэ. Хороо шаардлага хангасан гэж үзвэл бүртгэлийг сунгасан тухай мэдэгдэх ба үнэт цаас гаргагч нь шинэчлэгдсэн мэдээллийг нийтэд хүргэх үүрэг хүлээнэ.

3.14. Нэмж гаргасан үнэт цаасыг бүртгэснээс хойш 1 жилийн хугацаанд арилжаалж дуусаагүй бол бүртгэлийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9.8-д заасны дагуу хүчингүй болгоно.

3.15 Энэ журмын 3.11-д заасныг зөрчиж үнэт цаасаа нэрлэсэн үнээс өөр үнээр санал болгосон, 3.13-т заасан үүргийг биелүүлээгүй нь Хороо шинээр болон нэмж гаргасан үнэт цаасны бүртгэлийг хүчингүй болгох үндэслэл болно.

ДӨРӨВ. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах

4.1. Нэгдэх, нийлэх, хуваах хэлбэрээр хувьцаат компанийн зохион байгуулалтын хэлбэрийг өөрчлөх, нэмж хувьцаа гаргах, хувьцааг хуваах, нэгтгэх, тохиолдолд үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулна. Компанийн зохион байгуулалтын хэлбэрийг өөрчлөх, хувьцаа нэмж гаргах, хувьцааг хуваах, нэгтгэх тухай шийдвэрийг хувь нийлүүлэгчдийн хурал гаргана.

4.2. Хувьцаат компани нэмж хувьцаа гаргасан өөр компанитай нийлсэн, нэгдсэн, хуваагдсан, хувьцаагаа хуваасан болон нэгтгэсэн тохиолдолд компаниас ирүүлсэн хүсэлт, энэ журмын дагуу бүрдүүлсэн бичиг, баримтыг үндэслэн тэдгээрийн хувьцааны бүртгэлд өөрчлөлт оруулна.

4.3. Энэ журмын 4.1-д заасан шийдвэр гарснаас хойш ажлын 3 хоногийн дотор уг шийдвэрийг Хороонд ирүүлнэ.

4.4. Нэмж хувьцаа гаргасан тохиолдолд, хувьцаа гаргах тухай шийдвэр болон бусад холбогдох баримтыг энэ журмын хоёрдахь хэсэгт заасны дагуу бүрдүүлж ирүүлнэ.

4.5. Компани нийлэх, нэгдэх, хуваагдах, болон хувьцааг хуваах, нэгтгэх нөхцөл журам, өөрчлөн байгуулагдаж буй компанийн хувьцааг өөрчлөн байгуулалтаар бий болж буй компанийн хувьцаанд болон хуваасан, нэгтгэсэн хувьцаанд хөрвүүлэх харьцаа, өөрчлөлтөөр бий болсон компанийн хөрөнгийн хэмжээ, өр төлбөр, хүлээх үүрэг хариуцлага, өөрчлөн байгуулагдсан компанийн эрх, үүргийг өөрчлөлтөөр үүссэн компанид ямар байдлаар шилжүүлэх, компани өөрчлөн байгуулагдахтай холбогдон үүсэх хувь нийлүүлэгчдийн эрхийг хэрхэн хэрэгжүүлэх зэрэг асуудлыг тусгасан өөрчлөн байгуулах болон хувьцааг хуваах, нэгтгэх төслийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл боловсруулан, хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж баталсан байна.

4.6. Хувьцаат компани нийлэх, нэгдэх, хуваагдах, болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болон өөрчлөн байгуулагдаж байгаа тохиолдолд тухайн компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь хувь нийлүүлэгчдийн шаардлагаар хувьцааг эргүүлэн авах, хувьцааг хувааж, нэгтгэж байгаа тохиолдолд хувьцааны бутархай үлдэгдлийг худалдан авах үнийг тогтоосон байна.

Эргүүлэн авах үнийг тогтоохдоо Компанийн тухай хуулийн 56.4-т заасны дагуу хөндлөнгийн үнэлгээний байгууллагаас гаргасан дүгнэлтийг үндэслэнэ. Энэ үнэ нь уг хувьцааны дансны үнийн 80 хувиас доогуур тогтоогдсон бол үнэлгээний байгууллага эсхүл Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ үнийг тогтоосон үндэслэлийн талаар тайлбар, нотлох баримтыг дүгнэлтдээ хавсаргасан байна. Хувьцааны дансны үнийг тухайн компанийн үнэлгээ хийлгэхийн өмнөх сүүлчийн жилийн санхүүгийн тайлан балансад тусгагдсан цэвэр өөрийн хөрөнгийн дүнг гаргасан хувьцааны тоонд хувааж тодорхойлно.

4.7. Хувьцааг хуваах, нэгтгэх төсөлд хувьцааны бутархай үлдэгдлийг компани Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон үнээр худалдан авах, хувьцаа эзэмшигч хүсвэл зөрүүг мөн үнээр тооцож компанид төлснөөр бүхэл хувьцаа эзэмших эрхтэй байхаар заасан байна. Төслийг хувь нийлүүлэгчдийн хурлын зар мэдээг хүргэдэг журмаар хувь нийлүүлэгчдэд хүргэж саналыг авсан байна.

4.8. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлтийг дараах баримт бичгийн хамт Хороонд ирүүлнэ:

4.8.1. Компанийн тухай хуулийн 66.3-т заасан асуудлыг бүрэн тусгасан хувь нийлүүлэгчдийн хурлын тов, уг товыг хувьцаа эзэмшигчдэд хүргэсэн тухай мэдээлэл.

4.8.2. санал хураалтын дүнг баталсан тооллогын комиссын тогтоол;

4.8.3. компанийг өөрчлөн байгуулах болон хувьцааг хуваах, нэгтгэх төсөл; компани өөрчлөн байгуулагдсантай холбогдон хувь нийлүүлэгчдээс хувьцааг нь эргүүлэн худалдан авах болон хувьцааг, хуваасан, нэгтгэсний дараа үлдэх бутархай үлдэгдлийг худалдан авах үнэ, уг ажиллагааг зохион байгуулах журмыг баталсан Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр;

4.8.4. компанийг хуваах, өөр компанитай нийлүүлэх, нэгтгэх, хувьцааг хуваах болон нэгтгэх тухай хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр болон энэ журмын 5.1-д заасан бусад мэдээлэл;

4.8.5. компанийг өөрчлөн байгуулах комисс томилсон бол комиссын бүрэлдэхүүнийг баталсан шийдвэр, комиссын тайлан;

4.8.6. компанийг хуваах болон өөр компанитай нийлүүлэхэд хязгаарлагдмал хариуцлагатай компани үүссэн, ХК-ийг ХХК-тай нэгтгэж, цаашид ХХК-ийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулахаар шийдвэрлэсэн бол энэ журмын 5.3, 5.5, 5.6-д заасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн тухай тайлбар, мэдээлэл;

4.8.7. Хөрөнгийн бирж болон ҮЦТТХТ-д бүртгэлтэй үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахад Хөрөнгийн бирж болон ҮЦТТХТ-тэй байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийг тус тус бүрэн биелүүлсэн тухай тодорхойлолт;

4.8.8. Ногдол ашиг хуваарилсан байдал, хуваарилсан ногдол ашиг үлдэгдэлтэй бол уг хөрөнгийг ҮЦТТХТ-д холбогдох хувьцаа эзэмшигчийн нэр дээр байршуулсан баримт;

/Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 120 тоот тогтоолоор нэмсэн/

4.9. Хороо бүртгэлд өөрчлөлт оруулах тухай хүсэлтийг хянаж үзээд энэ журмын 5.3 болон 5.5, 5.6-д заасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлээгүй гэж үзвэл бүртгэлд өөрчлөлт оруулахаас татгалзаж болно.

4.10. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай Хорооны шийдвэр гарсны дараа ажлын 3 хоногт багтаан ажлын алба үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах бөгөөд энэ тухай ажлын 10 хоногт багтаан улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ.

***ТАВ. Хязгаарлагдмал хариуцлагатай компани
болон өөрчлөгдсөн хувьцаат компанийн
хувьцааг бүртгэлээс хасах***

5.1. Үнэт цаасаа нийгэд санал болгон худалдахаар Хороонд бүртгүүлсэн Хувьцаат компани /ХК/ хаалтай компани /ХХК/ болон өөрчлөгдөн зохион байгуулах шийдвэрийг хувь нийлүүлэгчдийн хурал хуралдаж, шийдвэр гаргаснаас хойш ажлын 3 хоногт багтаан Хороонд мэдэгдэнэ. Уг мэдэгдэлд дараах материалыг хавсарган ирүүлнэ:

5.1.1. компанийг өөрчлөн зохион байгуулах тухай хувь нийлүүлэгчдийн хурлын зар, тов, тэмдэглэл, хурлаас гаргасан шийдвэр, компанийг өөрчлөн зохион байгуулах төсөл, энэ талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр;

5.1.2. компанийг өөрчлөн байгуулах төсөлд дараах зүйлийг тусгана:

5.1.2.1. компанийг өөрчлөн байгуулах болсон шалтгаан, зорилго;

5.1.2.2. өөрчлөх нөхцөл журам;

5.1.2.3. хувьцааг хөрвүүлэх арга, тооцоо;

5.1.2.4. Компанийн тухай хуульд зааснаар компанийг өөрчлөн зохион байгуулах асуудлаар эсрэг саналтай байсан болон саналаа өгөөгүй хувь нийлүүлэгчдээс хуульд заасны дагуу хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх журам.

5.1.3. компанийг өөрчлөн зохион байгуулах шийдвэрийн төслийг хувь нийлүүлэгчдэд урьдчилан хүргэсэн тухай тайлбар, баримт бичиг;

5.1.4. хувьцааг эргүүлэн худалдан авах үнийг тогтоох тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр;

5.1.5. дээрх үнийн талаар үнэлгээний байгууллагын дүгнэлт, энэ үнэ нь энэхүү журмын 4.6-д заасан хэмжээнээс бага бол мөн хэсэгт заасан тайлбар;

5.1.6. *Хөрөнгийн бирж болон ҮЦТТХТ-д бүртгэлтэй үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахад Хөрөнгийн бирж болон ҮЦТТХТ-тэй байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийг тус тус бүрэн биелүүлсэн тухай тодорхойлолт;*

5.1.7. *Ногдол ашиг хуваарилсан байдал, хуваарилсан ногдол ашиг үлдэгдэлтэй бол уг хөрөнгийг ҮЦТТХТ-д холбогдох хувьцаа эзэмшигчийн нэр дээр байршуулсан баримт.*

/Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 120 тоот тогтоолоор нэмсэн/

5.2. Хорооны ажлын алба энэ материалыг хянан үзээд хувь нийлүүлэгчдийн хурал нь хүчин төгөлдөр болоогүй, шийдвэр нь хууль бус, өөрчлөн байгуулах төсөлд хуульд заасан зүйлсийг бүрэн тусгаагүй, хувьцааг эргүүлэн худалдан авах үнийг үндэслэлгүй доогуур тогтоосон гэж үзвэл энэ журмын 5.3-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэхийг хориглосон мэдэгдлийг компанид хүргүүлнэ. Уг мэдэгдэлд хориглож буй үндэслэлээ тайлбарласан байна.

5.3. Хорооноос өөрчлөн зохион байгуулах төсөлд заасан арга хэмжээг хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн албан тоот явуулсан бол хувь нийлүүлэгчдийн хурлаас өөрчлөн зохион байгуулах ажлыг эрхлэн гүйцэтгэхээр томилсон комисс, томилоогүй бол компанийн гүйцэтгэх удирдлага Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу хувь нийлүүлэгчдийн хуралд оролцоогүй хувьцаа эзэмшигч бүрт компанийг өөрчлөн байгуулах шийдвэр гарснаар хувьцаагаа эргүүлэн худалдахыг шаардах эрх үүссэн тухай болон эргүүлэн авахаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон үнэ, эргүүлэн худалдахыг шаардах эрхээ хэрхэн хэрэгжүүлэх талаар бичгээр мэдэгдэл хүргүүлнэ.

5.4. Хувьцаа эзэмшигчид энэхүү эрхээ хэрэгжүүлэх хугацаа нь мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 30 хоног байна. Мэдэгдэл нь алслагдсан аймаг, орон нутагт оршин сууж байгаа хувьцаа эзэмшигчдэд хүрэх, хариу ирүүлэх зэрэг хугацааг харгалзан мэдэгдэл явуулснаас хойш 2 сараас доошгүй байхаар тооцож саналыг хаах хугацааг тогтооно.

5.5. Хувьцаа эзэмшигчээс ирүүлсэн шаардлагын дагуу хувьцааны үнийг компанийн кассаас бэлэн мөнгөөр эсхүл харилцан тохиролцсоны дагуу эд хөрөнгийн хэлбэрээр олгосон, банкин дахь дансанд нь шилжүүлсэн, тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулдаг брокер, дилерийн компаниар дамжуулан олгосон зэргийг нотлох баримтад тулгуурлан хувьцааг нь эргүүлэн худалдан авсанд тооцно.

5.6. Дурдсан хугацаанд хариу ирүүлээгүй хувьцаа эзэмшигчийг хаалттай компанийн хувь нийлүүлэгчээр үлдсэнд тооцно. Гэхдээ хувьцаа эзэмшигч нь мэдэгдэл явуулсан хаяг байршилдаа байгаагүй, мэдэгдэл хоцорч очсон, хариу нь заасан хугацаанд ирж амжаагүй байж болзошгүй зэрэг нөхцөлийг харгалзан тэдний хувьцааг худалдан авахад шаардагдах мөнгөн хөрөнгийг үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллага дахь дансанд нь, хэрэв дансаа нээгээгүй бол данс нээж байршуулна.

5.7. Хувьцаа эзэмшигч өөрөө хаалттай компанийн хувь нийлүүлэгчээр үлдэх саналаа гаргавал дээрх мөнгийг компанид эргүүлэн шилжүүлж, санал гаргасан этгээдийг компанийн хувь нийлүүлэгчээр бүртгэн авч, улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ.

5.8. Өөрчлөн байгуулагдаж байгаа компани нь хувь нийлүүлэгчдийн хувьцааг эргүүлэн худалдан авах үйл ажиллагааг брокер, дилерийн компанитай юмуу Төлбөр тооцооны байгууллагатай гэрээ байгуулан, гэрээний дагуу хэрэгжүүлж болно.

5.9. Өөрчлөн зохион байгуулахаар шийдвэр гаргаж байгаа компанийн хувьцааны хяналтын багцыг эзэмшиж буй эрх бүхий албан тушаалтан, тэдний нэгдмэл сонирхолтой этгээд нь Компанийн тухай хуулийн 58.1-д заасан үүргээ хэрэгжүүлж, бусдынхаа хувьцааг худалдан авах саналаа Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нийцүүлэн Хорооноос баталсан журмын дагуу зарласан, мөн Компанийн тухай хуулийн 54.2-т заасан нөхцөл байдал бий болсон тохиолдолд хувь нийлүүлэгчид нь хувьцаагаа худалдан авахыг компаниас шаардах эрх үүссэн тухай мэдэгдэл хүргэж, хувьцаагаа эргүүлэн худалдаж авах ажиллагааг зохион байгуулсан байх шаардлагатай.

5.10. Өөрчлөн зохион байгуулагдаж байгаа компани нь дээрх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсний дараа Хороонд үнэт цаасаа бүртгэлээс хасуулах хүсэлтээ ирүүлэх бөгөөд уг хүсэлтэд дараах материалыг хавсаргасан байна:

5.10.1. Хувьцааг эргүүлэн худалдан авахад шаардагдах мөнгийг үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагад шилжүүлсэн баримт, байгуулсан гэрээний хуулбар;

5.10.2. Журмын 5.3; 5.5; 5.6; 5.8; 5.9 -д заасан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн талаархи танилцуулга, холбогдох баримт материал;

5.11. Компанийн үнэт цаасыг бүртгэлээс хасуулах тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор тухайн компанийн үнэт цаасны арилжааг улсын байцаагчийн шийдвэрээр зогсооно.

5.12. Энэ журмын 5.3; 5.5; 5.6; 5.8; 5.9-д заасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлээгүй гэж үзсэн тохиолдолд Хороо компанийн хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасахыг түдгэлзүүлж болно. Энэ тохиолдолд түдгэлзүүлсэн үндэслэлээ бичгээр мэдэгдэнэ.

5.13. Хороо өөрчлөн байгуулагдсан компанийн үнэт цаасыг бүртгэлээс хасах тухай шийдвэр гаргаснаас хойш ажлын 10 хоногийн дотор Улсын бүртгэлийн албанд мэдэгдэнэ.

ЗУРГАА. Татан буугдсан ХК-ийн үнэт цаасыг бүртгэлээс хасах

6.1. ХК-ийг татан буулгах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан тохиолдолд татан буулгах комисс энэ тухай Хороонд ажлын 3 хоногийн дотор мэдэгдэнэ.

6.2. Компанийг татан буулгах шийдвэрийн тухай мэдэгдэлд дараах баримт бичгийг хавсарган ирүүлнэ:

6.2.1. татан буулгах тухай болон татан буулгах комисс томилсон тухай эрх бүхий байгууллагын шийдвэр;

6.2.2. татан буулгах хугацаа, зээлдүүлэгчдийн нэхэмжлэлийг барагдуулсны дараагаар компанид үлдэж байгаа эд хөрөнгийг хувь нийлүүлэгчдэд хуваарилах журам зэргийг тусгасан татан буулгах төсөл, уг төслийг баталсан хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр;

6.2.3. компанийг татан буулгах болон нэхэмжлэл гаргах журам, хугацааг нийтэд мэдээлсэн тухай болон зээлдүүлэгчдэд бичгээр мэдээлсэн тухай баримт;

6.2.4. *Хөрөнгийн бирж болон ҮЦТТХТ-д бүртгэлтэй үнэт цаасыг бүртгэлээс хасахад Хөрөнгийн бирж болон ҮЦТТХТ-тэй байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийг тус тус бүрэн биелүүлсэн тухай тодорхойлолт;*

/Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 120 тоот тогтоолоор нэмсэн/

6.3. Компанийн үнэт цаасыг бүртгэлээс хасуулах тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор тухайн компанийн үнэт цаасны арилжааг улсын байцаагчийн шийдвэрээр зогсооно.

6.4. Татан буулгах комисс нь Компанийн тухай хуулийн 27, 28, 29 дүгээр зүйлд заасан журмын дагуу татан буулгах ажиллагааг гүйцэтгэж дууссаны дараа компанийг татан буулгах замаар үйл ажиллагаа дуусгавар болсон тухай Хороонд мэдэгдэнэ.

Уг мэдэгдэлд дараах бичиг баримтыг хавсаргасан байна:

6.4.1. татан буулгах түр болон дуусгалтын баланс;

6.4.2. компанийн эд хөрөнгийг худалдсан тохиолдолд уг хэлцэл нь сонирхлын зөрчилтэй хэлцэл байсан эсэх тухай тодорхойлолт, сонирхлын зөрчилтэй хэлцэл бол Компанийн тухай хуулийн 27.7-д заасны дагуу дуудлагын худалдаа явуулсан тухай мэдээлэл;

6.4.3. компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу өр төлбөрийг барагдуулсны дараа үндсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогыг хувьцаа эзэмшигчдэд хуваарилсан тайлан;

6.4.4. эзэмшиж буй хувьцаанд оногдох хөрөнгийг компаниас аваагүй хувьцаа эзэмшигчдэд оногдох мөнгийг үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагаар дамжуулан олгох тухай гэрээ, хувьцаанд оногдох мөнгийг шилжүүлсэн баримт;

6.4.5. *Ногдол ашиг хуваарилсан байдал, хуваарилсан ногдол ашиг үлдэгдэлтэй бол уг хөрөнгийг ҮЦТТХТ-д холбогдох хувьцаа эзэмшигчийн нэр дээр байршуулсан баримт.*

/Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 120 тоот тогтоолоор нэмсэн/

6.5. Үнэт цаасны бүртгэлээс хасах тухай шийдвэр гарснаас хойш ажлын 10 хоногийн дотор Хороо олон нийтэд болон Улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ.

***ДОЛОО. Үнэт цаасны тухай танилцуулга, мэдээллийг
нийтийн хүртээл болгох***

7.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 8-р зүйлд заасны дагуу үнэт цаас гаргагч нь шинээр болон нэмж гаргасан үнэт цаасны тухай танилцуулгыг Хороонд ирүүлсэн үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөлд хавсаргасан баримтад заасан арга, хэлбэрээр нийтийн хүртээл болгох, мэдээлж сурталчлах үүрэг хүлээнэ.

Сонирхогч бүх этгээд танилцуулгад агуулсан мэдээллийг олж авах боломжийг хангасан бол нийтийн хүртээл болгосон гэж үзнэ.

7.2. Тухайн үнэт цаасны тухай танилцуулгыг бүтнээр нь дэлгэрэнгүй хэвлэн нийтлэхийг шаардахгүй бөгөөд энэ журмын хавсралт 6-д заасны дагуу шинээр болон нэмж гаргасан үнэт цаасны товч танилцуулгыг нийтэд мэдээлнэ.

7.3. Арилжаа эрхлэх болон зуучлах байгууллага, үнэт цаас гаргагч нь нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасны талаар мэдээлэл авахыг хүссэн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг уг үнэт цаасны талаархи дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцах боломжоор хангана.

7.4. Үнэт цаас гаргагч, үнэт цаасыг бүртгэсэн, түүнд өөрчлөлт оруулсан, мөн бүртгэлээс хассан тухай Хорооны шийдвэрийг үндэслэн зохих тайлбар шалтгааныг тодруулан зааж, уг үнэт цаасыг эзэмшигч болон олон нийтэд мэдээлэх үүрэг хүлээнэ.

7.5. Нийтэд санал болгон гаргасан болон нэмж гаргасан үнэт цаас эсвэл үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсан, бүртгэлээс хассан тухайн шийдвэрээ Хороо өөрийн веб хуудсаар болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлнэ.

---- оО о ---

/2007 оны 08 дугаар сарын 17-ны өдөр хүртэлх өөрчлөлтийг тусгав/

Хавсралт 1

НИЙТЭД САНАЛ БОЛГОН ГАРГАСАН ҮНЭТ ЦААСЫГ
БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь заалтыг үндэслэн

_____ /үнэт цаас гаргачийн нэр/

_____ оны .. сарын ..-ны өдрийн шийдвэрээр нийтэд
/эрх бүхий байгууллагын нэр /
санал болгон үнэт цаас гаргасныг бүртгүүлэхээр өргөдөл гаргаж байна.

1. Үнэт цаас гаргагчийн:

1.1. Оноосон нэр -----

1.2. Хаяг-----

1.3. Улсын бүртгэлийн дугаар -----

1.4. Регистрийн дугаар -----

2. Үнэт цаасны зах зээл дээр зуучлах мэргэжлийн байгууллагын:

2.1. Оноосон нэр-----

2.2. Хаяг-----

2.3. Улсын бүртгэлийн дугаар -----

2.4. Регистрийн дугаар -----

3. Гаргах үнэт цаасны:

3.1. нэр-----

3.2. төрөл -----

3.3. тоо-----

3.4. нэрлэсэн үнэ -----

3.5. хугацаа-----

3.6. гаргасан нөхцөл / хямдруулсан, хөвөх , тогтмол хүүтэй, хугацаанаас нь өмнө
эргүүлэн татах г.м./ -----

4. Үнэт цаас гаргаж хуримтлуулах хөрөнгийн зориулалт -----

5. Үнэт цаасны зах зээлд зуучлах мэргэжлийн байгууллагын баталгааны агуулга

6. Ирүүлсэн баримт бичгийн үнэн зөвийг бүрэн хариуцах бөгөөд хөрөнгө оруулагчид
тохиолдож болзошгүй эрсдлийг танилцуулгад бүрэн тусгасан болно.

Өргөдөл гаргасан:

(нэр, албан тушаал, тэмдэг)-----

200. оны .. дугаар сарын ..-ны өдөр

Хавсралт 2

**НИЙТЭД САНАЛ БОЛГОН ГАРГАСАН
ҮНЭТ ЦААСНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА****А.Ерөнхий мэдээлэл**

1. Үнэт цаас гаргагчийн нэр, хаяг, үйлдвэрлэл үйлчилгээний үндсэн чиглэл
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын овог, нэр, хаяг, утас, түүний нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж буй хувьцааны тоо, хувь;
3. Гүйцэтгэх захирлын овог, нэр, хаяг, утас, түүний нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж буй хувьцааны тоо, хувь;
4. Компанийн охин болон хараат компанийн нэр, байршил, эзэмшил, хяналтын хувь хэмжээ
5. Компанийн нийт гаргасан хувьцааны хяналтын багцыг эзэмшигчдийн нэр, хаяг, утас;/нэгдмэл сонирхолтой этгээдүүд хамтран эзэмшдэг бол төлөөлөх этгээд/
6. Эдгээр нь Компанийн тухай хуулийн 58.2-т заасан үүргээ биелүүлсэн эсэх;

Б.Үнэт цаасны тухай танилцуулга

1. Гаргасан үнэт цаасыг бүртгэх тухай Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэрийн огноо, дугаар;
2. Гаргасан үнэт цаасны:
 - нэр, төрөл;
 - гаргах хэлбэр /биет, биет бус/;
 - тоо хэмжээ;
 - нэрлэсэн буюу худалдахаар санал болгож буй үнэ;
 - үнэт цаасыг гаргасан нөхцөл /эргүүлэн татах нөхцөлөөр бонд гаргасан бол гүйлгээнд байх доод хугацаа, хаалттай захиалгаар хувьцаа гаргасан бол худалдан авахаар санал болгож буй этгээдийн нэр, хаалттай хүрээнд санал болгож буй шалтгаан, санал болгож буй үнэ, энэ үнийг тогтоосон үндэслэл/ хувьцаа нэмж гаргаж байгаа бол тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхийг хэрэгжүүлэх журам, үнэ.
3. ХХК-ийг нээлттэй ХК болгон өөрчлөн байгуулж, нийтэд санал болгон хувьцаа гаргаж байгаа бол хаалттай компанийн хувьцаа нь нээлттэй компанийн хэдэн ширхэг хувьцаа болон хөрвөсөн, энэ нь нийт хувьцааны хэдэн хувийг эзэлж байгаа.
4. Үнэт цаасыг арилжаалах график, анхдагч зах зээлд байршуулж дуусах огноо;
5. Хуримтлуулах хөрөнгийн зориулалт.

6. Үнэт цаас эзэмшигчид учирч болох эрсдэл.

7. Үнэт цаасыг арилжаалах, зуучлах байгууллага. Тэдгээрийн хаяг, харилцах утас.

8. Үнэт цаасны дэлгэрэнгүй танилцуулгатай танилцаж болох газар, хаяг, утас, хэнтэй харилцах.

В. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдал:

Санхүүгийн тайлангийн үзүүлэлт, сүүлийн 3 жилийн ашиг, борлуулалт, үзүүлэлтийг Хорооны 2003 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 45 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу мэдээлнэ.

ҮНЭТ ЦААС ГАРГАСАН ТУХАЙ ТАЙЛАН

А.Тайлангийн нүүрний хуудас

Үнэт цаас гаргагчийн нэр, хаяг, байршил-----
 Үнэт цаасны нэр, төрөл -----
 Үнэт цаасыг бүртгэхийг зөвшөөрсөн Хорооны шийдвэрийн огноо-----
 Үнэт цаас гаргагчийн:
 - Гүйцэтгэх захирлын нэр, гарын үсэг -----
 - Ерөнхий нягтлан бодогч нэр, гарын үсэг -----
 Үнэт цаас гаргагчийн
 Тэмдэг

Тайлан гаргасан огноо:

Б.Тайлангийн агуулга:

1.Шинээр болон нэмж гаргасан үнэт цаасыг арилжаалж эхэлсэн болон дууссан огноо;

Үнэт цаасыг хаалттай хүрээнд худалдсан бол төлбөр хийгдсэн хэлбэр, огноо;
 Өрийг хувьцаагаар сольсон бол төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагад хувьцааг авлагатай этгээдийн нэр дээр бүртгэсэн огноо;

Бондыг /өрийн бичиг/ багц багцаар нь хэсэгчлэн худалдсан бол багц бүрийг худалдсан огноо;

2.Гаргасан үнэт цаасны нэрлэсэн үнэ.

3.Худалдсан үнэт цаасны тоо.

4.Худалдсан үнэт цаасны арилжааны дээд, доод, дундаж ханш;

Хэрвээ үнэт цаасыг захиалгын журмаар хаалттай хүрээнд худалдсан бол түүний үнэ;

Хэрвээ өрийг хувьцаагаар сольсон бол нэгж хувьцааны үнийг хэдэн төгрөгөөр тооцсон;

5.Үнэт цаасны төлбөрийн тухай мэдээлэл:

а. мөнгөн хөрөнгө, үүнээс үндэсний болон гадаад валютаар хийгдсэн төлбөр;

б. оюуны өмч, оюуны өмчөөр төлбөр хийсэн этгээдийн нэр, Оюуны өмчийн газарт бүртгэгдсэнийг нотлох баримт, үнэ, үнэлсэн тухай мэдээлэл;

в. эд хөрөнгийн хэлбэрээр төлбөр хийгдсэн бол уг хөрөнгийн үнэ, үнийг тогтоосон үндэслэл, үл хөдлөх хөрөнгө бол түүний гэрчилгээ үнэ тогтоосон эрх бүхий байгууллагын дүгнэлт, эргэлтийн хөрөнгө бол уг хөрөнгийн үнийг зөвшөөрч баталсан эрх бүхий этгээдийн шийдвэрийн огноо, дугаар;

г. эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр хийгдсэн бол төлбөрт тооцож эд хөрөнгө эзэмших эрхээ шилжүүлсэн этгээдийн нэр, уг эрхийг эзэмшигч болохыг болон уг эрхийг үнэт цаас гаргагчид шилжүүлснийг нотолсон баримт;

6. Үнэт цаасыг нэрлэсэн үнээс дээгүүр үнээр худалдан борлуулснаас орсон нэмэгдэл орлогын хэмжээ үнийн дүнгээр.

7. Бүх төрлийн үнэт цаасыг худалдан борлуулахад хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн жагсаалт, уг хэлцлийг баталсан эрх бүхий байгууллагын шийдвэрийн хуулбар.

8. Хувьцаа гаргасан тухай тайлан гаргаж байгаа бол гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг дангаар болон нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт худалдан авсан этгээдийн нэр, нийт эзэмшиж буй хувьцааны тоо, хувь.

Хувьцаат компани шинээр байгуулагдахад гаргасан хувьцааны тайлан гаргаж байгаа бол шинээр байгуулагдсан хувьцаат компанийн эрх бүхий албан тушаалтны нэр, овог, эзэмшиж буй хувьцааны тоо, хувь.

Тайлбар: Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл, компанийн эрх бүхий албан тушаалтныг Компанийн тухай хуульд заасны дагуу тодорхойлно.

Хавсралт 2

ХУВЬЦААНЫ ЗАХИАЛГЫН ХУУДАС

-----аймаг /нийслэл/-ийн байгуулах / өөрчлөн
байгуулах/ гэж байгаа компанийн нэр-----

Захиалга авсан он .. сар .. өдөр .. цаг .. мин

1.Захиалагч байгууллагын нэр -----

2.Бүртгэлийн дугаар -----

-Оноосон нэр -----

-Оршин байгаа газар -----

-Харилцах данс -----

3.Захиалсан хувьцааны төрөл-----

Тоо ширхэг -----

Нэрлэсэн үнэ -----

Нийт үнэ -----

4.Захиалга хийхийг зөвшөөрсөн эрх барих дээд байгууллагын шийдвэрийн дугаар,
огноо/шийдвэрийн хуулбарыг хавсаргана/-----

5.Захиалгын төлбөр хийх хэлбэр хугацаа -----

Нөхцөл -----

6.Захиалгын төлбөр хийх хугацааг сунгасан эсэх, тэмдэглэл-----

7.Захиалгын биелэлт/төлбөрийн баримтыг хавсаргана/-----

8.Захиалга эс биелсэн тохиолдолд урьдчилсан төлбөрийг буцаан олгосон сар, өдөр-----

Захиалга өгсөн
байгууллагын дарга
/тэмдэг/

/ гарын үсэг/

Захиалга авсан

/гарын үсэг/

Хавсралт 3

ХУВЬЦААНЫ ЗАХИАЛГЫН ХУУДАС

-----аймаг/нийслэл/-ийн байгуулах гэж байгаа
компанийн нэр-----

Захиалга авсан он .. сар .. өдөр .. цаг .. мин

1.Захиалагч хувь хүний овог, нэр -----

2.Паспортын сери, регистрийн дугаар -----

-Оршин байгаа газрын хаяг -----

-Харилцах утас -----

3.Захиалсан хувьцааны төрөл-----

Тоо ширхэг -----

Нэрлэсэн үнэ -----

Нийт үнэ -----

4.Захиалгын төлбөр хийх хэлбэр

Хугацаа -----

Нөхцөл -----

5.Захиалгын төлбөр хийх хугацааг сунгасан эсэх -----

6.Захиалгын биелэлт/төлбөрийн баримтыг хавсаргана/-----

7.Захиалга эс биелсэн тохиолдолд урьдчилсан төлбөрийг буцаан олгосон сар, өдөр-----

Худалдан авах захиалга өгсөн

хувь хүний гарын үсэг -----

Захиалга авсан хувьцаа

гаргахыг хүсэгч -----

/гарын үсэг/

Хавсралт 4

ХУВЬЦААНЫ ЗАХИАЛГЫН БҮРТГЭЛ

-----захиалга хүлээн авагчийн нэр

№	Захиалга			Албан ёсны хаяг
	Хувьцаа захиалагчийн	Паспорт, гэрчилгээний дугаар	Утас	
1	2	3	4	5

Захиалга өгсөн хугацааны бүртгэл				
Он	Сар	Өдөр	Цаг	Мин
6	7	8	9	10

Авах хувьцааны захиалга				Захиалга авсан хүний албан тушаал, гарын үсэг
11	12	13	14	15